

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2023 ОНЫ 3 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

03-р сарын 19-нд сумын “Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн” зохион байгуулж, “Сүхбаатарчууд бид” төрийн бус байгууллагын сургагч багш, докторант Ө.Марал болон магистр багш М.Оюунтөгс нарыг урьж “Харилцаа хандлага”, “Ажил гэр бүлийн тэнцвэрт байдал”, “Байгууллагын соёл, үнэт зүйлс”, “Стресс, менежмент”, “Төрийн албан хаагчдын манлайлал” “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвүүдээр сургалт, лекц авлаа. Уг үйл ажиллагаанд төрийн 5 байгууллагын 102 албан хаагч хамрагдсан. Мөн сургалт зөвөлгөөнд сумын төсөвт байгууллагуудын дарга эрхлэгчид, нийгмийн даатгал, нийгмийн халамж, татварын улсын байцаагч нар холбогдох хуулийн чиглэлээр сургалт мэдээлэл өглөө. Зөвөлгөөний төгсгөлд байгууллагын дарга эрхлэгчид болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлалаа.

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Алсын хараа- 2050” баримт бичгийн талаарх цахим сургалтад сумын төсөвт 5 байгууллагын 100 албан хаагч хамрагдаж сертификатаа авсан.

Иргэдийн санаачлагаар сумын залуучууд иргэдэд нөлөөлөх үйл ажиллагааны хүрээнд “АА” сургалтыг Сүхбаатар аймгийн “Мандах наран” “Зөв боломж”, Түмэнцогт сумын “Түмэн эх”, Мөнххаан сумын “Саруул ухаан”, Баяндэлгэр сумын “Ухаалаг алхам” Эрдэнэцагаан сумын “Шинэ өглөө” бүлгүүдтэй хамтран 7 хоногт 3 удаа тогтмол зохион байгуулж байна.

3 дугаар сарын 15-21-ний өдрүүдэд багийн дарга нар суурь тойролтоор ажиллалаа.

МУ-ын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолын дагуу “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, үзүүлсэн тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ын хэрэгжилтийн мэдээг аймгийн Гэр бүл , хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн.

2023-2024 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид шинээр элсэн суралцах 85 хүүхдийн судалгааг гаргаж ЕБС-д хүргүүлсэн.

Алдарт эхийн 1 болон 2 дугаар одон авах болзол хангасан 13 эхчүүдийн материалыг хүлээн авч архивын нэгж болгон аймгийн ТЗУХ-т хугацаанд нь хүргүүлэв.

3 дугаар сард E-mongolia оператороос 5 иргэн лавлагаа мэдээлэл авсан байна. Сумын вэб хуудсанд цаг үеийн болон сарын ажлын мэдээ, нийт 1 удаа мэдээлэл оруулсан.

Сумын Засаг даргын А/09 тоот захирамжаар Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг томилуулан ажиллаж байна.

0 3 дугаар сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3469, өрх 1004, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн 18 , нас барсан 1 хүн бүртгэгдсэн.

ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сар бүрийн 8-ны дотор байгууллагуудын сарын төсөв гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл бусад мэдээ мэдээллийг шилэн дансанд шивж байна.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн. Орон нутгийн ерөнхий орлого, татварын орлогын гүйцэтгэлийн мэдээг шилэн дансанд шивсэн. Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Төсөвт байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2023 оны төсвийн хуваарийг шилэн дансанд шивсэн.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Долоо хоног бүрийн даваа гарагт хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг программд тогтмол оруулж байна.

2023 оны 03 дугаар сарын байдлаар Хоршоо хөгжүүлэх сангийн нийт 16 зээлдэгч байгаа ба хугацаа хэтэрсэн чанаргүй 6 зээлдэгч, хэвийн 10 зээлдэгч байна. Нийт 177.880.149 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сумын нэгдсэн хогийн цэг болон зохиулалтын бус газарт төвлөрсөн хогийг хамж булшлах ажлыг зохион байгуулж одоогоор 206 машин буюу 824 тонн хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлээд байна.

АДАПТ төсөл болон усны мэргэжлийн “Престиж инженеринг” ХХКомпанийн холбогдох мэргэжилтэнүүдтэй хамтран 2023-2028 онуудад хашиж хамгаалах

болон цаашид анхаарч байх булгийн судалгааг гаргаж уг төслийн хугацаанд хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллалаа.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газарт сумын иргэдийн ундны усны чанарыг сайжруулах хүсэлт гарган, сумын төвийн худгуудын ариун цэврийн лабораторийн шинжилгээний бичгийг хүргүүлсэн байна. Хүйтэн-3 худагт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах хүсэлт хүргүүллээ.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт долоо хоног бүр хорогдлын мэдээ хүргүүлж байна. 03 сарын 20-ны байдлаар сумын хэмжээнд бог мал 4478 , бод мал 1322, нийт 5800 мал хорогдоод байна. ХАА10, ХАА2 том малын хорогдлын мэдээг программд шивж оруулсан. Хорогдлын мэдээнд тулгуурлан хорогдол ихээр гарсан өрхүүдэд өвс тэжээл хямдралтай үнээр олгохоор төлөвлөн ажиллаж байна.

Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 2021 оны малын тоог өөрчилж 2022 оны тоо болгон шивэх ажлыг дуусгаад байна. 868 өрхийн малын тоог тулган шинэчлэн шивсэн байна.

Үржлийн малын 1%-д үзлэг ангилалт хийхэд шаардлагатай ээмэгний захиалгыг аймгийн хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Газар тариалангийн нэгдсэн системд 2 ААНБ, 4 иргэнийг бүртгэж, тариалалтын төлөвлөгөө шивж оруулав.

3 дугаар сарын 2, 3-нд “Монгол Ви и ти нэт” ТББ, аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран малын эмч нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад сумын 5 малын эмч оролцлоо. Сургалтаар адууны хөлийн эмгэгүүд, туурай хөл боох, баасанд өндөг хөвүүлэх, цусны улаан эс, цагаан эс тоолох, жижиг амьтанд сав тайрах ажилбар хийх, эмийн зохистой хэрэглээ зэрэг сэдвээр мэдээ мэдээлэл авсан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

НИЙГМИЙН ХАЛАМЖ: 2023 оны 03-р сард 2020-2022 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан хөтөлбөрт хамрагдсан 14 иргэн 1972500 мянган төгрөг төвлөрүүлэхээс 8 иргэн 1094000 мянган төгрөгийн ХЭДС-ийн 100120037010 тоот дансанд төвлөрүүлсэн.

"ХЭДС-аас олгогдох "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа", "Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг", "Ахмад мэргэжилтэний зөвлөх үйлчилгээ", "Ахмадын хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг"-ийн хөтөлбөрүүдийн зарыг сумын цахим групп болон утсаар нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

МУЗГ-ын 2023 оны "Хүүхдийн мөнгөн тэтгэмж" олгох журам гарсантай холбогдуулан иргэдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг биеэр, утсаар, цахим хэлбэрээр, нийт 12 иргэн ехаламж прораммаар шалгууллаа.

2021-2023 оны байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдаж буй нийт 229 иргэдийн судалгааг маягтын дагуу гарган хүргүүлсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдсан 7 иргэнд 354548 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар гарган бэлтгэн өгч нөхөн олгуулсан.

Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг хийж нийгмийн халамжийн асаргааны тэтгэмжид 6 иргэний сунгалт хэлэлцэн тэтгэмжид хамруулсан.

03-р сард нийгмийн халамжийн еhаламj системид нийгмийн халамжийн тэтгэвэрт шинээр-1 иргэн, сунгалт 1 иргэн, "Цалинтай ээж" хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмжид 7 иргэнд, жирэмсэн эхийн тэтгэмжид 8 иргэнд, нийт 17 иргэний мэдээллийг бүртгэж тэтгэвэр тэтгэмжид бүрэн хамруулсан.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР: ЕБС: Байгууллагын эрсдлийг бууруулах ажлын хэсэг нь улирлын ээлжит гадаад дотоод орчинд дүн шинжилгээ хийж сургууль дотуур байр орчимд нийт 15 эрсдлийг илрүүлэн, галч нар болон слесарь эрэгтэй ажилчид уг 15 зөрчлийг арилгаж хүүхдийн аюулгүй орчныг бий болголоо. Уг үйл ажиллагаанд 9 хүн, 5 өдөр ажиллаж, 70000 төгрөг зарцууллаа.

Энэ сард аймагт зохиогдсон оюун ухааны наадамд 5 багш, 12 суралцагч оролцлоо. Мөн хүүхдийн спортын наадамд 2 багш, 29 суралцагч оролцлоо.

3 дугаар сард сургуулийн менежментийг сайжруулах төлөвлөлтөд тусгасан багш нарын гүйцэтгэлийн үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын "Гарц-Шийдэл- Амжилт" хэлэлцүүлгийг сургуулийн нийт багш нар, сургуулийн удирдлагууд хамтран зохион байгууллаа.

Мөн энэ сард залуу багш нарын манлайллыг нэмэгдүүлэх ээлжит хичээл бүрийг бэлтгэлтэй заах уриан дор "Өдөр бүр-Нээлттэй хичээл" аяныг зохион байгуулж ажлын хэсгийн 5 хүн залуу багш бүрийн 2 хичээлд суулаа.

3-р сарын 11-нд “АЗИА МОНГОЛИА” төслөөс хэрэгжиж байгаа мэдээллийн технологийг хэрэглээ болгох, сурагчдад код бичих чадвар эзэмшүүлэх төслийн нээлттэй танилцуулгыг сургууль дээр зохион байгууллаа.

3-р сарын 16-нд сургуулийн бүсгүйчүүдийн зүгээс эрчүүдийн эрүүл мэндэд анхаарч спорт өдөрлөг зохион байгууллаа.

3-р сарын 22-нд 12-р ангийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн удирдлага, Анги удирдсан багш, ЭЕШалгалтад бэлтгэж байгаа багш нарын хамтарсан “Ирээдүйнхээ төлөө хамтдаа” уулзалт ярилцлагыг амжилттай зохион байгууллаа. Тус уулзалтад 12-р ангийн бүх сурагч тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагчын төлөөлөл оролцлоо. Сургуулийн зүгээс ЭЕШалгалтын бэлтгэл хангалт, амьдралын гараа, сонголт хийх хариуцлагатай үе ирснийг суралцагч, эцэг эхэд санууллаа.

Сүхбаатар аймгийн бүх сум, сургууль, цэцэрлэгийн багш сурагчдын “Оюун ухааны наадам-2023” тэмцээнд сургууль, цэцэрлэгийн багш сурагч, эцэг эхийн төлөөлөл 13 хүн оролцов.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотноо 2023 оны 3 дугаар сарын 18-19 нд “УЛСЫН ТӨРӨЛЖСӨН ОЛИМПИАД”-ын 2-ын даваанд ЕБС-аас 13 төрлийн хичээлээр багш нар сурагчдаа бэлтгэж оролцлоо. Оролцсон багш сурагчдаас 1 багш, 3 суралцагч амжилт гаргаж, шагналт байранд орлоо.

Мөн энэ сард Залуу багш нарын дунд ээлжит хичээлийн бэлтгэл сайжруулах сарын аян зарлаад явж байна. Аяны хүрээнд багш нар ухаалаг самбар дээр үзүүлэх хичээл заасан.

1 дүгээр ангийн 85 сурагчдад "Чихэртэй уншлага" хийж үсэг нүдлэлт , унших чадварт хяналт хийлээ. 2-5 ангийн сурагчдаас монгол хэлний хичээлээр "Уншъя, Сэтгэе, Ойлгоё" уралдааны 3 – р шатны уралдаанд оролцлоо,

1-5 дугаар ангийн хүүхдүүдийн дунд “ Илүүдэл жингүй Эрүүл Монгол хүүхэд” аян зарлаж, аяны хүрээнд хүүхэд бүрийн биеийн жин, өндрийг үзэж биеийн жингийн индексийг гаргасан. Нийт 301 хүүхэд хамрагдсан. Одоогийн байдлаар илүүдэл жинтэй- 6, таргалалтай-1 хүүхэд тус тус илэрсэн. Тэдгээр хүүхдүүдэд зөвлөгөө өгч, хооллолтын зуршилд хяналт тавьж байна. Мөн аяны хүрээнд Дотуур байрын суралцагчдад “Эрүүл зохистой хооллолт, Хүнсний аюулгүй байдал”сэдвээр сургалт хийж ярилцав. 1-5-р ангийн суралцагчдын Хооллолтын байдал, харшлын судалгааг нийт 382 хүүхдийн 340 хүүхэд хамрагдсан.

Цэцэрлэг: Сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр сар бүр “Сайн хичээл” үйл ажиллагааг зохион байгуулж хэвшээд байна. Энэ сард бүлгийн багш нарын дунд амжилттай зохион байгуулагдаж 9 багш үйл ажиллагааг явууллаа. Үүний үр дүнд сургалтын хэрэглэгдэхүүний тоо нэмэгдэж хүүхэд бүрт хүртээмжтэй болж байна.

Энэ сард байгууллагын дотоод хяналт шалгалтыг 1 удаа зохион байгуулж гарсан зөрчил дутагдалыг арилгах арга хэмжээг авлаа.

Ажлын байранд 2 сургалт зохион байгуулагдаж 45 хүн хамрагдсан бол цахим сургалтад 3 удаа 34 хүн, үндсэн сургалтад 4 хүн хамрагдаж байна.

Орон нутгийн сургалтад 1 удаа 10 хүн хамрагдаж 100000 төгрөгийг зарцуулсан.

Байгууллагын багш ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор байгууллагын аварга шалгаруулах теннисний тэмцээнийг 2 насны ангиллаар зохион байгууллаа.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: 3 дугаар сард 3 удаагийн урлагийн тоглолт зохион байгуулж, тоглолтуудад нийт 339 үзэгчид үйлчлүүлж, мөн нийтийн цэнгээнт бүжгийг 5 удаа зохион байгуулсан.

Энэ сарын 17-19-ний өдрүүдэд соёлын төвийн дарга, БМСанч нар Улаанбаатар хотод ажиллаж “Чингис хаан” үндэсний музейтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж гэрээ байгууллаа. Эртний эдлэл цуглуулагчдын холбооны нарийн бичгийн дарга нутгийн уугуул Ц.Батсайхантай уулзаж орон нутаг судлах танхимын тохижилт үйл ажиллагааны талаар харилцан ярилцаж энэ үеэр Ц.Батсайхан нь эртний олдвор бүхий том жижиг 5 ширхэг хүрэл толийг орон нутаг судлах танхимд хандивлалаа.

“Уран жиргээ” хүүхдийн уралдааны 1-р шатыг амжилттай зохион байгуулж нийт 58 сурагч хамрагдсан. Мөн 2-р шатанд оролцох хүүхэд багачуудыг бэлтгэн ажилласан.

Соёлын төвийн дэргэдэх нийтийн номын сан нь 2023 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу гэрээр ном олголт 152, танхимын ном олголт 187, номын сангаар 370 уншигч үйлчлүүлсэн байна.

Номын сангийн дэргэдэх “Номын клуб” дугуйланд 14 сурагчид “Судар Эгшиглэн 2023” төсөлд байгууллагын 4 албан хаагч оролцож байна. Морин хуур даралтат хөгжим дуу бүжгийн дугуйлангууд цагийн хуваарийн дагуу хичээллэж байна.

Үндэсний биет бус өвийг өвлөн уламжлуулах сурталчлах зорилгоор насанд хүрэгчдийн дунд 3 дугаар сарын 17,18-ны өдрүүдэд “Багийн шагай харваа” “Шагай шүүрэх” “Сонирхогчдын цуваа харваа” тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа. Багийн харваанд 8 багийн нийт 40 харваачид , шагай шүүрэх тэмцээнд 22 иргэн, сонирхогчдын цуваа харваанд 21 иргэн оролцсон. Мөн аймгийн шагай харваа тэмцээнд явах харваачидыг бэлтгэл хийх байраар хангаж дэмжлэг үзүүлсэн.

Монгол орон даяар зохион байгуулагдсан “Музейн нээлттэй өдрүүдээр” ЕБС-ын бага, дунд ангийн сурагчдын дунд музейн аялал, музейн боловсролын хөтөлбөрийн хүрээнд монгол гэрийн түүх, үүсэл хөгжил, гэрийн бүтэц дотоод зохион байгуулалтын талаар сургалт өгч, 76 сурагч хамрагдлаа.

Соёлын төв дэргэдэх 9 төрлийн дугуйланд нийт 108 сурагчид хамрагдан суралцаж байна. “Шидэт бийр” зургийн дугуйланд 18 сурагч хамрагдаж зураг зурах, баримлын шавраар өнгийн цаасаар цэцэг наах гэх мэт бүтээлүүд хийж сурч байна. Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан хөтөлбөрт үйл ажиллагааны тайз орчинг бүрдүүлэхэд анхаарч хүүхдүүд өөрсдийн бүтээсэн бүтээлийг ээжүүддээ бэлэглэж зураг татуулах орчинг бүрдүүлж ажиллалаа. Мөн 1 жилийн ойгоо угтан хүүхдүүдийнхээ дунд “Бяцхан зураачдын ур чадвар” тэмцээн, “Шинэ ертөнц” зохион бичлэгийн уралдаануудыг зарлаад байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан сумын Эмэгтэйчүүдийн холбоотой шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулж, сумын албан байгууллага, иргэдийн дунд 1970-1980 оны эстрад хамтлаг дууны уралдаан зохион байгуулж ажилласан. Мөн ЕБС-тай хамтран “Хөөрхөн охид” уулзалтыг ахлах ангийн 53 охидыг хамруулан зохион байгуулсан

Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тохиолдуулан “Эрчүүдийн нэг өдөр” хөтөлбөрт арга хэмжээний хүрээнд “Багийн шагай харваа”, “Шагай шүүрэх”, “Сонирхогчдын цуваа харваа” тэмцээнүүдийг зохион байгуулж нийт 83 харваачид оролцлоо. Мөн “Багийн талын хөзөр” тэмцээн зохион байгуулж 8 багийн 24 иргэн оролцов.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 151, алсын дуудлага 8, гэрийн дуудлага 3, хэвтэн эмчлүүлэгч 30.

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газраас халдвараас сэргийлэх хяналтын бүсчилсэн сургалт зөвөлгөөнийг 15,16-ны өдрүүдэд сумын ЭМТ-д зохион

байгууллаа. Уг сургалтанд баруун талын сумд болох Мөнххаан, Уулбаян, Түмэнцогт, Халзан, Баяндэлгэр сумдын Эрүүл мэндийн төвийнн 40 гаруй тооны халдвар хамгааллалын багийхан 2 өдрийн турш хамрагдсан.

Сар болгоны товллын вакциныг 58 хүүхдэд хийгээд байна.

“Энэ жилдээ эрүүл жиндээ”, “Өөрчлөлтийг хурдасгая”, “Тууралтат халдварт өвчин”, “Давсны хэрэглээг бууруулах”, Сүрьеетэй тэмцэх дэлхийн өдөр, дэлхийн усны өдөр зэрэг сургалт хөтөлбөрийн хүрээнд цахим болон заалны сургалт сурталчилгааг зохион байгуулаад байна.

Тухайн сард лабораторын хийсэн шинжилгээ үйлчилгээ: Сахар – 9, Серологи – 1, Шээсний дэлгэрэнгүй-13, Элэгний В, С-2, биохими -1 шинжилгээ тус тус хийгдсэн байна.

Тайлан нэгтгэсэн:

ХЭЗМэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг